



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/123

Баян-Өндөр сум

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах зөвлөлийн 60 жилийн ойн
хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө,
төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.5.1 дэх заалт, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн "Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай" А/169 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 60 жилийн ойн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ойн арга хэмжээний хүрээнд гарсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, явц, үр дүнг танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч, Бодлого төлөвлөлт, хууль эрх зүйн хэлтсийн дарга (Б.Тунгалаг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.МӨНХБАТ

Албан хэрэгцээнд

6125070271

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын
2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн
А/Б дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зохион байгуулах ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх албан тушаалтан
1	"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны нэгдсэн өдөрлөг" арга хэмжээг зохион байгуулах	IX/12	Ажлын хэсэг	Салбар зөвлөлийн дарга, гишүүд
2	Төрийн байгууллагууд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	X/01-XI-05	Ажлын хэсэг	-Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс -Баян-Өндөр сумын ИТХ-ын Ажлын алба -Цагдаагийн газар
3	Зөвлөлийн гишүүдийн дунд спортын гурван төрөлт тэмцээн зохион байгуулах	IX/12	Ажлын хэсэг	-Аймгийн БТСГ
4	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны талаарх сэтгүүл бэлтгэн гаргах	IX/01-IX/12	Ажлын хэсэг	Аймгийн ИТХ-ын даргын хэвлэлийн төлөөлөгч Л.Ганцолмон, ажилтан А.Цэдэн-Иш
5	Зөвлөлийн гишүүд болон иргэдийг шагналд тодорхойлох ажлыг зохион байгуулах	IX/01-IX/12	Ажлын хэсэг	Салбар зөвлөлийн дарга, гишүүд
6	Салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, зөвлөлийн хуралдааны дэгийг батлуулах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн биелэлтийг хэлэлцэж, иргэд олон нийтэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын явцын талаар мэдээлэл түгээж ажиллах	IX/19	Ажлын хэсэг	Салбар зөвлөлийн дарга, гишүүд

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын
2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн
A/123 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

- Б.Тунгалаг
Аймгийн ИТХ-ын Бодлого төлөвлөлт, хууль эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

- М.Мөнхбаяр
Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга
- П.Батболд
Аймгийн Ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх
- А.Лхагвадорж
Аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа
- Э.Алтанбат
ТЕГ-ын Орхон аймаг дахь газрын дарга, хошууч
- Б.Майдармаа
Аймгийн Гаалийн газрын дарга
- Ш.Баасандорж
Аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа
- Э.Эрдэнэбат
Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга
- Ш.Билгүүнбаатар
Жаргалант сумын ИТХ-ын дарга
- Д.Гантөмөр
Дотоодын цэргийн 816 дугаар ангийн захирагч, хурандаа
- А.Ганбаяр
Аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн дарга, хошууч
- Д.Болортунгалаг
Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга:

- Г.Ган-Эрдэнэ
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хариуцсан ажилтан

БАТЛАВ
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ТУНГАЛАГ

2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр

**“ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАМТЫН
АЖИЛЛАГАА” НЭГДСЭН ӨДӨРЛӨГИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Хариуцах албан тушаалтан
1	“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа” нэгдсэн өдөрлөгийн талаарх мэдээллийг иргэд болон холбогдох газруудад мэдээлэл хүргэх	- Г.Ган-Эрдэнэ
2	Зөвлөгөөнийг зохион байгуулах техник зохион байгуулалтын бэлтгэл хангах (асар, тайз, дэлгэц, сандал)	- Г.Ган-Эрдэнэ
3	Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг оролцуулах	- Г.Ган-Эрдэнэ
4	Хөтлөгчид арга хэмжээний талаарх мэдээллийг хүргэх, төрийн дуулал эгшиглүүлэх ажлыг зохион байгуулах	- Г.Ган-Эрдэнэ
5	Сэтгүүл гаргах	- Б.Тунгалаг - А.Лхагвадорж - Г.Ган-Эрдэнэ
6	Спортын арга хэмжээг зохион байгуулах	- Д.Гантөмөр - Э.Алтанбат
7	Спортын заалны захиалга өгөх	- Г.Ган-Эрдэнэ
8	Урлагийн тоглолт	- П.Батболд - М.Майдармаа - А.Ганбаяр
9	Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн байгууллагууд байгууллагын онцлогийг харуулсан үзүүлэх тоглолтын бэлтгэл	- А.Лхагвадорж - Ш.Баасандорж - Д.Гантөмөр
10	Өдөрлөгт төрийн байгууллагуудын удирдлага болон багийн Засаг дарга нарыг оролцуулах арга хэмжээг авч ажиллах, (тухай багт гэмт хэрэгт холбогдох эрсдэл бүхий 10 иргэнийг оролцуулж, хууль эрх зүйн зөвлөгөө авах)	- М.Мөнхбаяр - Э.Эрдэнэбат - Ш.Билгүүнбаатар
11	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн танилцуулга бэлтгэх	- Д.Болортунгалаг
12	Шагналд тодорхойлсон материалыг хүргүүлэх	- Г.Ган-Эрдэнэ
13	Оройн хоолны арга хэмжээг зохион байгуулах	- Д.Болортунгалаг - Г.Ган-Эрдэнэ
14	Өдөрлөгийн үеэр нийгмийн дэг журам сахиулах ажлыг зохион байгуулах	- А.Лхагвадорж